



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар Б/80.

Чингис хот

Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоо,
чиг үүргийн хуваарийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ХЭГ/1433 тоот “Тогтоол хэрэгжүүлэх асуудлаар чиглэл өгөх тухай” албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоо, албан хаагчдын ажлын чиг үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Орон тоо, албан хаагчдын ажлын чиг үүргийн хуваарь өөрчлөгдсөнтэй холбогдуулан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 2016 оны 12 дугаар сарын 01-нд багтаан шинэчлэн батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/60 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2013 оны Б/43 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ж.ГАНБААТАР